



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/411

Хэрлэн сум


### Сургалтад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.4.11 дүгээр заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.11 дэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Номт өндөрхаан” НҮТББ-аас залуучуудын дунд зохион байгуулж буй мэргэжлийн боловсрол олгох сургалтын зардалд 1,500,000 (нэг сая таван зуу) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн “Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаагаар дамжуулан жил тутам залуучуудын оролцоог 50 хувиар, үйд ажиллагаанд хамрагдалтыг 10 хувиар нэмэгдүүлнэ” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ